

## Learning to work with letters and numbers

Family resources

# Үсэг болон тоотай ажиллаж сурах

Гэр бүлд зориулсан материал

Сургуулийн Өмнөх Боловсролын бодлого (Early Years Learning Framework) нь цэцэрлэг болон бага насны хүүхдэд зориулсан бүх төрлийн үйлчилгээ явуулдаг байгууллагуудын мөрдөх үндэсний хэмжээний боловсролын бодлого юм. Хүүхдийг зорилгот таван чиглэлээр сургаснаар тухайн хүүхэд сурах хатуужил, өндөр чадвартай болоход нь энэхүү бодлогын зорилго юм.

Сургалтын 5-р үр дүн бол хүүхдүүд үр дүнтэй мэдээлэгч байх тухай юм. Энэ нь тэд хэл суралцаж, мөн илтгэл, үлгэр болон дуунд гарах хэв маяг болон чимээг сонсож, түүнд хариу үйлдэл үзүүлж сурах болно. Хүүхдүүд өдөр тутмын амьдралдаа технологи ашиглан шинэ мэдээлэл авч мөн өөрсдийн санаагаа илэрхийлж чаддаг байх болно. Тэд тоо, тоо тоолох, хэмжих болон дүрс гэх мэт математикийн ойлголтуудыг сурч мэдэх болно.

Early Years Learning Framework-ийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах линкээр орж танилцана уу:  
<https://www.acedca.gov.au/nqf/national-law-regulations/approved-learning-frameworks>

## Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл хүүхдийнхээ цэцэрлэг эсвэл бага насны хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай холбогдоорой. Хэрвээ утсаар холбогдоход танд орчуулагчийн тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэл дээрх орчуулагчтай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны хүссэн дугаар руу залган мөн тухайн шугамд орчуулагчийг таньтай холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.

## Сургуульд суралцах

### Сургуулийн Өмнөх Боловсрол

#### Үр дүнтэй мэдээлэгч байх гэдэг нь:

Хүүхдүүд тоонууд, тоо тоолох болон хэмжилтийг өдөр тутмын амьдралдаа ашиглаж чаддаг байна

Хүүхдүүд үлгэр болон дууг сонсон, ойлгож мөн зохиож чаддаг байна

Хүүхдүүд өөрсдийн соёлоос төрөлх хэл дээрээ үлгэр ярина

Хүүхдүүд хөгжим, дүрд тоглох, урлаг болон бүжгээр дамжуулан сурсан зүйлээ хуваалцан, мэдээллэх чадвартай байна

Сурагчид өөрсдийн санаагаа хөгжүүлэн мөн илэрхийлж сурна (Сэдвүүд: Англи хэл болон Математик)

Сурагчид сонсож, ярьж, уншиж, болон бичиж харилцах чадвартай болно (Сэдвүүд: Англи хэл болон Математик)

Сурагчид өдөр тутмын амьдралдаа математикийн ур чадваруудыг ашиглаж сурна (Сэдэв: Математик)

Сурагчид сургууль дээр болон өдөр тутмын амьдралдаа бусадтай харилцахдаа технологи ашиглаж сурна (Сэдэв: Мэдээлэл болон харилцааны технологи)